

**“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-ЫН ХЭРЭГЖИЛТ**  
/Соёл, урлагийн газар/

<b>3.1.4.Соёл иргэншлийн аюулгүй байдал</b>		
	<b>Арга хэмжээ</b>	<b>Хэрэгжилт</b>
1.	3.1.4.1	<p>Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ. Дэлхийн Монгол судлалын төвийг Улаанбаатарт байгуулж монголч эрдэмтдийг судалгааны ажлуудад татан оролцуулах, бусад оронд салбар байгуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>1.Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын бүтээлч орон зайг бүрдүүлэх зорилгоор "Угийн бичиг", "Даам тоглож сурцгаая" танхим, кино урлагаар дамжуулан "Мини театр"соёлын боловсрол олгох орчинг тус тус бүрдүүлсэн.</p> <p>2.Аймгийн Төв номын сангаас зохион байгуулсан "Номонд дурлагсад" богино хэмжээний цуврал нэвтрүүлэгт 10 хүн оролцож цахимаар 6809 хүнд хүргэсэн.</p> <p>3.Аймгийн Төрийн 11 байгууллагын 63 албан хаагчдын дунд "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан.</p> <p>4.Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг Төв номын сан 2 удаа 87 хүн, Хүүхдийн номын ордон 9 удаа 281 хүн, Шарын гол сумын Соёлын төв 2 удаа 43 хүн, Хонгор сумын соёлын төв 1 удаа, 57 хүнийг тус тус хамруулсан.</p> <p>5."Угийн бичиг хөтлөх" ач холбогдол, түүний тэмдэглээний талаарх 18 мэдээлэл бэлтгэж цахимд байршуулж иргэд олон нийтэд сурталчиллаа.</p> <p>6.ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй "Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд шавь сургалтын танхимыг тус аймгийн Хүүхдийн номын ордонд нээж "Хотон" бий биелэгээний сургалтад 1 албан хамрагдсан.</p> <p>7."Өв соёлын цаг" сэдвийн хүрээнд "Шагайн наадгайн төрөл", "Шагайн наадгай" сэдвээр 2 контент, "Дээл" сэдвээр 1 видео контент тус тус бэлтгэж өөрийн пейждээ байршуулан 1474 хэрэглэгчдэд хүргэсэн.</p> <p>8."Бүх нийтийн соёлын боловсрол" хөтөлбөрийн хүрээнд МУ-ын СББӨ-ийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад аймгийн Соёл, урлагийн газрын 2 албан хаагч хамрагдана. <b>Нийт 8 арга хэмжээг зохион байгуулж 8827 иргэдийг хамруулсан.</b></p>
2.	3.1.4.2	<p>Монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг нэмэгдүүлнэ.</p> <p><b>-“Үндэсний бичиг соёлын жил-2024”-ийн хүрээнд 13 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:</b></p> <p>1.Соёл, урлагийн газар болон соёлын 7 байгууллага албаны үйл ажиллагаандаа Монгол бичгийн цахим сурах бичиг, толь бичиг, хөрвүүлэх программыг нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд дээрх байгууллагууд нийт 62 албан бичгийг хос бичгээр үйлдсэн.</p> <p>2.Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн судалгаанд соёлын байгууллагын 116 албан хаагч, Монгол бичгийн танхимын шалгалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.</p>

			<p>3.Соёлын байгууллагууд "Хүмүн бичиг" сонинг улирал бүр захиалж өглөөний уншлага хийж хэвшсэн.</p> <p>4.Соёлын байгууллагын 8 албан хаагч удирдлагын академийн Монгол бичгийн дунд шатны сургалтад цахимаар хамрагдлаа.</p> <p><b>-“Хос бичигтэн” арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 16 арга хэмжээнд 11503 иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулж, дэмжиж ажилласан. Үүнд:</b></p> <p>1.Харьяа номын сангуудтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "Уран уншлага"-ын уралдааныг 8 удаа зохион байгуулж 79 иргэнийг хамруулсан.</p> <p>2."Хос бичигтэн-2025" эрдэм шинжилгээний хуралд ЕБС-ийн 32 багшийг хамруулсан.</p> <p>3.Үндэсний бичгийн "Түргэн уншлага", "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэг, "Эх хэлээ эрхэмлье" сайхан бичгийн уралдаанд нийт 460 иргэнийг хамруулсан.</p> <p>4."Үндэсний бичгийн хурдан уншигч" уралдаанд 12 албан хаагч хамрагдсан.</p> <p>5. "Монгол бичгийн тийн ялгал" сэдэвт сургалтыг Музейн албан хаагчдад зохион байгуулав.</p> <p>6. "Монголын Төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэлд хийсэн судалгаа", "Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо дээдэлье" сэдэвт ахисан шатны сургалтыг зохион байгуулж <b>Нийт үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлын хүрээнд нийт 20 арга хэмжээг зохион байгуулж 11628 гаруй иргэнийг хамруулсан.</b></p>
3.	3.1.4.3	<p>Хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх хүрээнд Соёлын 3 байгууллага "Эх оронч Дарханы ирээдүй" өдөрлөгийг 2024.05.08-12-ны хүртэл 5 хоногийн хугацаанд хамтран зохион байгуулж <b>435 хүүхдийг хамруулсан:</b> Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Номын сангийн боловсролын хөтөлбөрт 91 хүүхэд,</li> <li>• Танин мэдэхүйн хөгжөөнт "АХА" тэмцээнд 169 хүүхэд,</li> <li>• Дууны уралдаанд 59 хүүхэд,</li> <li>• Номын үзэсгэлэнд 116 хүүхэд,</li> </ul> <p>2. "Оюунлаг Дарханчууд" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 19 арга хэмжээг 150 удаа зохион байгуулж 8732 хүнийг хамруулсан.</p> <p>-“Оюунлаг Дархан” дэд хөтөлбөрийн /2021-2023/ соёлын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг гарган Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж хэлэлцүүлсэн.</p> <p>-“Оюунлаг Дарханчууд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтээр соёлын 4 байгууллага 4 контент бэлтгэж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. <b>Нийт 21 арга хэмжээг зохион байгуулж 8732 хүнийг хамруулсан.</b></p> <p>3.Төрийн үйлчилгээний соёлын 7 байгууллага 28 төрлийн боловсролын хөтөлбөрийг 95 удаа зохион байгуулж 8568 хүүхдийг хамруулсан байна.</p>


			<p>4. Орон нутгийн судлаач, зохиолчдыг дэмжих чиглэлээр Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Хонгор сумын соёлын төвөөс “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг 8 удаа зохион байгуулж 560 гаруй сурагч, иргэдийг хамруулсан. Суманд 1 удаа зохион байгуулсан.</p> <p>5. Тус газрын харьяа Залуучууд театр, сумдын Соёлын төвийн дэргэд хичээллэж буй 18 дугуйланд 269 суралцагч хүүхдүүд хамрагдсан.</p>
4.	3.1.4.4	<p>үндэсний ёс заншил, соёл урлагийн нэртэй төлөөлөгчид, ардын авьяаснуудын уйгагүй хөдөлмөр, зүтгэлийг үнэлэх, алдаршуулах, эрдэм авьяасыг нь өвлүүлэх бодлого, үйл ажиллагааг төрөөс хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Дархан-Уул аймгийн хэмжээнд 84 өвлөн уламжлагч <a href="http://www.ich.mongoluv.mn">www.ich.mongoluv.mn</a> улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байдаг ба үүнээс МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын харьяат 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулж ЮНЕСКО-ийн яаралтай болон төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлөн уламжилж, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх үүргээ биелүүлж буйд Талархал илэрхийлэв.</p> <p>2.ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ын нээлтэд 12, Хэл хуурчдын анхдугаар чуулганд 3, “Монгол улсын шилдэг өвлөн уламжлагч” номинацид 1, “Мөнгөн мод 2023” наадамд 3, “Монгол туургатан хэл хуурын танхим байгуулах” 1, “Өв соёлоо дээдэлъе” тоглолтод 12, МҮОНТ-ийн “Монгол Түмний Мэнд” нэвтрүүлэгт СББӨ-ийг өвлөн уламжлагч гэр бүлийн 5 гишүүнийг, “21 Өв, соёл” нэвтрүүлэгт 1 зэрэг 8 арга хэмжээнд 38 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан.</p> <p>3.Шарын гол 6, Орхон сум 22, Хонгор сум 7 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг тус тус сум орон нутагтаа сурталчлан алдаршууллаа.</p> <p>4.Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хүрээнд 8 сургалт, уулзалт, үзэсгэлэн арга хэмжээг 28 СББӨ-ийг өвлөн уламжлагчтай хамтран зохион байгуулж үйл ажиллагааны 5 мэдээг 15,970 цахим үзэгчдэд хүргэсэн.</p> <p>5.Дархан-Уул аймгийн 14 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан 10 ярилцлага, нэвтрүүлгийг RGB, ЦЭЦ.мн телевизүүдтэй хамтран бэлтгэж цахимаар 273,859 үзэгчдэд хүргэсэн.</p> <p>6. СББӨ-ийн өвлөн уламжлагч, Угийн бичгээ 9 дэх үедээ хөтөлж буй Г.Мягмарын “Угийн бичиг хөтлөх” арга зүй, түүний ач холбогдлын тухай танилцуулга видео бэлтгэн цахимд байршуулж иргэд олон нийтэд сурталчиллаа.</p> <p>7. Хүүхдийн номын ордон, Шарын гол, Хонгор сумын соёлын төв нийт 4 иргэний угийн бичгээр үзэсгэлэн гаргаж иргэд олон нийтэд сурталчилсан.</p> <p>8. Дархан-Уул аймгийн Орхон сумын 1 дүгээр багийн иргэн СББӨ-ийг өвлөн уламжлагч Дорж овогтой Зоригтыг Уламжлалт арга ухаан: Угийн бичиг хөтлөх өвийг эзэмшсэн төрөл зүйлээр улсын бүртгэл мэдээллийн санд бүртгэв.</p> <p><b>-Нийт МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын харьяат 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулж, 8 арга хэмжээнд 38 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан.</b></p>

			<p><b>-Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвүүд нийт 35 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг алдаршуулсан.</b>  <b>-Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хүрээнд 8 сургалт, уулзалт, үзэсгэлэн арга хэмжээг 28 СББӨ-ийг өвлөн уламжлагчтай хамтран зохион байгуулж, тус аймгийн харьяат 14 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан ярилцлага нэвтрүүлгийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран бэлтгэж олон нийтэд сурталчиллаа. Нийт 114 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг алдаршуулсан байна.</b></p>
5.	3.1.4.6	<p>Дэлхийн бусад орон, түүний дотор гуравдагч хөрш орнуудтай соёлын салбарт өргөн харилцаа хөгжүүлж, дипломат төлөөлөл, иргэдээрээ дамжуулан монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.</p>	<p>1."Go Mongolia" аяны хүрээнд Соёлын яамнаас 21 аймаг, сум, дүүргийн дунд зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнд тус аймгаас "Найрамдлын Дархан өргөө" гэрээр оролцож 12928 иргэдэд монгол гэрийн уламжлалт урлал, зан үйлийг сурталчлах, өвийг түгээн дэлгэрүүлэх, монголын өв уламжлал, соёлын үнэт зүйлсийг сурталчлан таниуллаа.                  2.Найрамдал төслийн хүрээнд зохион байгуулагдсан нээлттэй форум хэлэлцүүлэгт оролцсон 9 орны 130 гаруй зочид төлөөлөгчдөд зориулж Залуучууд театрын уран бүтээлчид Ардын язгуур урлагийн тоглолтоор үйлчилсэн.                  3."Монгол гэр" үзэсгэлэнгийн хүрээнд зарласан эрдэм шинжилгээний хуралд Дархан нутаг судлаач, Дэд профессор Музейн захирал Д.Жамбалдорж "Монгол гэрийн үүсэл хөгжил" сэдвээр илтгэл хэлэлцүүллээ.                  4.Австрали улсын Сидней хотод зохион байгуулагдсан олон улсын хүүхдийн фестивальд Монгол сургуулиа төлөөлж Дэлхийн соёлын өвийн жагсаалтад орсон морин хуур, монгол бүжгээрээ Монголыхоо соёлыг түгээж амжилттай оролцлоо.                  5. 2024 оны 06 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд ЮНЕСКО-ийн Театр Урлагийн Институтийн Косово дахь салбар "МоноАкт"аас зохион байгуулах Олон улсын нэг хүний жүжгийн 16 дэх уралдаант фестивальд тус аймгийн Залуучууд театрын жүжигчин Ч.Дунгаамаа "Хайрт минь, энэ зөвхөн эхлэл нь" жүжгээр оролцсон.                  6. Гладнесс бүжгийн студийн 12 хүүхэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан "World ballet grand prix" тэмцээнд, Дархан хотын "Бундын тамга" хамтлагийн 6 гишүүнийг БНСУ-руу аялан тоглолтоо хийхэд тус тус дэмжлэг үзүүлж ажиллалаа. <b>Нийт 6 арга хэмжээг зохион байгуулсан.</b></p>
6.	3.1.4.7	<p>Түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарахаас сэргийлэх, хилийн чанадад дахь монгол соёл иргэншлийн өвийг сурвалжлан олох, судлах, эх орондоо эгүүлэн залах, сэргээн засах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг дэмжиж, гадаад оронтой идэвхтэй хамтран ажиллах</p>	<p>1.Соёлын Өвийн Үндэсний Төвд сэргээн засварлах шаардлагатай үзмэрийн судалгааг гаргаж, 35 дэсийн 38 ширхэг уран зураг засварлуулах хүсэлт хүргүүлсэн. Тус хүсэлтийн дагуу СӨҮТ-өөс 2024 оны 05/21 тоот албан бичгээр "Ачаа ачигч", "Мөнх найрамдлын тууль", "Мөнх найрамдал", "Давхарын өртөө", "Их нүүдэл", "Үйлдвэрийн Дархан" зэрэг 6 уран зургийг СӨҮТ рүү актаар хүлээлцэн хүргэх ажлыг соёлын өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу гүйцэтгэсэн.                  2. 2024 оны 01 дүгээр сард сэргээн засварлагдсан авдар, хул аяга, морин хуур зэрэг 3 үзмэрийг хүлээн авч сан хөмрөгт хадгалав.  <b>Сэргээн засварласан Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл 3 ширхэг, сэргээн засварлуулахаар өгсөн 6, Соёлын баримтат өв 32 ширхэг, Бурхан шашны байгууллагад хадгалагдаж байгаа бүртгэлд хамруулсан соёлын өвийг улсын бүртгэл мэдээллийн санд 53 эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулав.</b></p>

		эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авна.	
7.	3.1.4.8	Уламжлалт Бурханы шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ.	Музейн хүндэтгэлийн буланд дэглэгдсэн Дархан-Уул аймгийг хот болсонтой холбогдуулан Засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай зарлиг, Дархан хотод хороо захиргаа байгуулах тухай зарлиг, Шарын гол сумын хороог орон нутгийн хот болгох тухай зарлиг, Хороо байгуулах тухай зарлиг, Сэлэнгэ аймгийн Хонгор сумыг хороо болгож харьяаллыг өөрчлөх тухай зарлиг, Хороо байгуулах тухай зарлиг буюу зэрэг нийт 6 баримтат өвийг судалгаанд хамруулав. Дархан сумын 11 дүгээр багийн иргэн Н.Амгаланд үе дамжин хадгалагдан ирсэн Догсо судар, Банзрагч судар, Алтангэрэл судар, Ил захидал, Бакула рембучи Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлан хийдэд ирсэн зураг зэрэг 5 баримтат өвийг бүртгэв. Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлан хийдийн 12 баримтат өвийг бүртгэсэн. Дархан сумын 12 дугаар багийн иргэн Х.Мөнхцэцэгт хадгалагдаж буй 15 зурмал бурхан, 1 хос болор толь зэрэг 17 баримтат өвийг бүртгэн баримтжууллаа. Шарын гол сумын Мэргэн даяанчийн Гэлэгпэлжэйлин хийдэд хадгалагдаж буй 21 Дарь Эх, Очирваань, Гонгор, Ямандаг зэрэг 4 танка зургыг бүртгэн баримтжуулсан. Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлан хийдийн лам Ёндонжамцад 5 үеэс хадгалагдаж байсан 5 баримтад өвийг бүртгэв. <b>Тайланг хугацаанд иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа нийт 32 баримтат өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэж, тайланг салбарын хяналтын <a href="https://mcc.igovernment.mn/">https://mcc.igovernment.mn/</a> цахим санд сар бүр оруулж баталгаажуулж ажиллав.</b>
8.	3.1.4.1	Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурханы шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ.	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд 20 дугаар зүйлийн 20.6.3-т сүм хийдэд орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Гэцогдайржайлин хийдийн албан хүсэлтээр Аймгийн Музейн хамт олон тус хийдэд хадгалагдаж буй соёлын биет өвийг бүртгэн баримтжуулах ажлыг 2024 оны 3 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Тус бүртгэн баримтжуулалтын ажлаар үнэт, ховор зэрэглэлд ангилагдах 53 эд өлгийн зүйлийг Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн (ББЗМаягт10)-ийн дагуу бүртгэл үйлдэж түүх, соёл, шинжлэх ухааны эрдэм шинжилгээний тодорхойлолт гаргах, гэрэл зураг авах, үзмэр эд өлгийн зүйлийн бодит жин, хэмжээг авч бүртгэн баримтжуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.ДОЛГОРМАА